



ДУНДГОВЬ АЙМАГ  
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/129

Сангиндалай

Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг  
хязгаарлаж, хяналт тавих тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.11 дэх заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12.2, 7.12.3 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын нутагт бог малын мялзан өвчин бүртгэгдэж хорио цээрийн дэглэм тогтоосонтой холбогдуулан өвчин дамжин тархах эрсдэлээс сэргийлэх зорилгоор бог малын шилжилт хөдөлгөөнийг 2023 оны 12 сарын 31-ний өдөр хүртэл түр хугацаагаар хориглосугай.

2. Гадны аймгийн отор нүүдлийг 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор тус сумын нутаг дэвсгэрээс заасан маршрутын дагуу бүрэн гаргахыг цагдаагийн хэсгийн дарга, дэд хурандаа (Л.Лхагвагарам) Эрэн хайх аврах салбын дарга, Онцгой байдлын ахлах дэслэгч (Б.Энхтөр), багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Малчдад гоц халдварт өвчний талаар мэдээлэл өгч, отор нүүдэл, шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг мал эмнэлгийн тархвар зүйч (Т.Машбат), энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой комиссын дарга (Г.Энхдэлгэр) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Отор нүүдлийн хөдөлгөөнийг дамжин өнгөрүүлэх маршрутыг хавсралаар баталсугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



О.БАЗАРРАГЧАА

482302257